



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 05 сарын 17 өдөр

Дугаар A/86

Ховд

Тамга, тэмдэг түших, хэвлэмэл хуудас
хариуцах ажилтанд өөрчлөлт оруулах тухай

Архивын тухай Монгол Улсын хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолын 4 дүгээр бүлгийн 36, 37 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын тамга, хэлтсийн даргын тэмдгийг Засаг даргын нарийн бичгийн даргаар, Тамгын газрын даргын тамга, тэмдгийг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнээр, Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөлийн тэмдгийг Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар, Хууль зүйн хэлтсийн тэмдгийг Хууль, эрх зүйн хэлтсийн даргаар, аймгийн Архивын тасгийн тамгыг тасгийн даргаар тус тус түшүүлж, байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудсыг бичиг хэргийн эрхлэгчид хариуцуулсугай.

2.Тамга, тэмдэг түшиж, хэвлэмэл хуудас хариуцаж байгаа ажилтнууд тамга тэмдэг, хэвлэмэл хуудсыг зориулалтын саванд хадгалж тамга тэмдгийг түр шилжүүлсэн тохиолдолд бүртгэл хөтлөн хүлээлцэх, албан бичгийн хэвлэмэл хуудсыг зохих заавар, стандартын дагуу хэрэглэхийг холбогдох ажилтнуудад даалгасугай.

3.Тушаалд өөрчлөлт орсонтой холбогдуулан 2018 оны A/179 дүгээр тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

02 00335
D/TC-A/86-Da